



ХОВД АЙМАГ  
МӨСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2014 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 1/49

Улаантолгой

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь заалт 48 дугаар зүйлийн 48.2.2 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Улаантолгой багийн "гэр хороололын гэрэлтүүлэг"-г нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Нямаа - Санхүү албаны дарга  
Гишүүд: С.Ульянов -Хүн эмнэлгийн нягтлан бодогч  
Г.Мөнхзаяа -Иргэний төлөөлөл  
Б.Мягмарсүрэн –Мэдээлэл технологийн ажилтан

Нарийн бичгийн дарга: Б.Идэрбаян -ХАА-н мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг үнэлгээний хорооны дарга /Б.Нямаа /-д үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Идэрбаян /-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.БААСАНДОРЖ